



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/88

Улаанбаатар хот

Хуваарь, чиг үүрэг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ын 2.2.2 дахь хэсгийн 2 дугаар зорилтыг тус тус үндэслэн Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын 2.4.1.8 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Эх барих, эмэгтэйчүүд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүд, зөвлөх эмч, мэргэжилтнүүдийн орон нутгийг хариуцан ажиллах хуваарь, ажлын чиг үүргийг нэгдүгээр, Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүд, зөвлөх эмч, мэргэжилтнүүдийн орон нутгийг хариуцан ажиллах хуваарь, ажлын чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хариуцсан орон нутгуудад дэмжин туслах ажлыг зохион байгуулах, мэргэжлийн удирдлага, арга зүйгээр ханган ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/-т, Эх барих, эмэгтэйчүүд судлалын мэргэжлийн салбар зөвлөл /Б.Мөнхцэцэг/-д, Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөл /Б.Баясгалантай/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-т даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 474 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080330

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 03 сарын 04 ны өдрийн  
№... дугаар тушаалын 1 дүгээр  
188 хавсралт



**ЭХ БАРИХ, ЭМЭГТЭЙЧҮҮД СУДЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ГИШҮҮД, ЗӨВЛӨХ ЭМЧ, МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ОРОН НУТГИЙГ ХАРИУЦАН  
АЖИЛЛАХ ХУВААРЬ, АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ**

**1.1. АЖИЛЛАХ ХУВААРЬ**

№	Нэрс	Албан тушаал	Зэрэг, цол	Аймгийн нэр
1.	Г.Баттулга	ЭХЭМҮТ, ЭБЭЭ-ийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал	АУ-ны доктор, тэргүүлэх зэргийн эмч	Булган, Хөвсгөл
2.	Г.Дашзэвгэ	ЭХЭМҮТ, ЭБЭЭ-ийн зөвлөх эмч	АУ-ны магистр, Зөвлөх зэргийн эмч	Говь-Алтай
3.	Ч.Мөнхбаяр	ЭХЭМҮТ, Эмэгтэйчүүдийн эмгэгийн тасгийн эрхлэгч	АУ-ны магистр, Тэргүүлэх зэргийн эмч	Архангай, Өмнөговь
4.	Д.Мөнхцэцэг	АШУҮИС, ЭБЭС-ын тэнхимийн эрхлэгч	АУ-ны доктор	Дорнод, Дундговь
5.	Г.Мэндсайхан	АШУҮИС, ЭБЭС-ын тэнхимийн багш	АУ-ны доктор	Говьсүмбэр, Төв
6.	Ц.Үржиндэлгэр	ЭХЭМҮТ, Нөхөн үржихүйн зөвлөх поликлиникийн эрхлэгч	АУ-ны магистр, Тэргүүлэх зэргийн эмч	Дархан-Уул
7.	С.Хишгээ	ЭХЭМҮТ, ЭБЭЭ-ийн зөвлөх эмч	АУ-ны доктор, Зөвлөх зэргийн эмч	Завхан, Хэнтий
8.	Я.Хишигсүрэн	ЭХЭМҮТ, ЖЭЭТ-ийн эрхлэгч	АУ-ны магистр, Тэргүүлэх зэргийн эмч	Өвөрхангай
9.	М.Энхжаргал	ЭХЭМҮТ, ЖЭЭТ-ийн эмч	АУ-ны магистр, Тэргүүлэх зэргийн эмч	Баянхонгор
10.	Ж.Энхтуяа	ЭХЭМҮТ, Төрөх тасгийн эрхлэгч	АУ-ны магистр, Тэргүүлэх зэргийн эмч	Орхон, Сэлэнгэ
11.	Ж.Энхцэцэг	АШУҮИС, ЭБЭС-ын тэнхимийн ахлах багш	АУ-ны доктор	Дорноговь, Увс
12.	Т.Эрхэмбаатар	АШУҮИС, ЭБЭС-ын тэнхимийн ахлах багш	АШУ-ны доктор, профессор	Ховд
13.	Д.Янжинсүрэн	АШУҮИС, ЭБЭС-ын тэнхимийн ахлах багш	АУ-ны доктор, дэд профессор	Баян-Өлгий, Сүхбаатар

## 1.2 АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ

1.2.1. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, төлөвлөгөөний төсөлд санал өгч, дэмжлэг үзүүлэх;

1.2.2. Эх барих, эмэгтэйчүүд, нярайн тусламж үйлчилгээний чиглэлээр мөрдөгдөж буй стандарт, журам, заавар, тушаалын хэрэгжилтэд хяналт тавих;

1.2.3. Амаржих газрууд, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эх барих, эмэгтэйчүүд, нярайн тусламж, үйлчилгээний байдалтай танилцах, зөвлөгөө өгөх;

1.2.4. Мэргэжлийн чиглэлээр ажлын байрны сургалт зохион байгуулах;

1.2.5. Эх барих, эмэгтэйчүүд, нярайн тусламжийн зохион байгуулалтын болон мэргэжлийн тусламжийг үзүүлэх;

1.2.6. Эх эндсэн тохиолдолд орон нутагт ажиллаж, эмнэлзүй, эмгэг судлалын хурлыг удирдаж, цаашид уг алдааг давтахгүй байх зөвлөмж өгөх;

1.2.7. Эх барих, эмэгтэйчүүд, нярайн нэн шаардлагатай болон яаралтай тусламжийн байнгын бэлэн байдал, эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн хангамж, хүний нөөцийн хүрэлцээ, чадавхийг үнэлж, орон нутгийн шийдвэр гаргагчдад танилцуулж, асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

1.2.8. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээ (үр хөндөлт, гэр бүл төлөвлөлт, БЗДХ, өсвөр үе, цэвэршилтийн нас)-ний байдалтай танилцах, зөвлөгөө өгөх;

1.2.9. Орон нутгийн эх барихын ерөнхий мэргэжилтэн, нөхөн үржихүйн эрүүл мэндийн зохицуулагч болон эмч нартай байнгын уялдаа холбоотой ажиллаж зөвлөгөө өгөх;

1.2.10. Өвчтөнийг дээд шатлалд шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

1.2.11. Мэргэжлийн эмч нарт цахимаар зөвлөгөө өгөх;


1.2.12. Орон нутагт ажилласан тохиолдолд тайлан бичиж Эрүүл мэндийн газрын удирдлага, эх барих эмэгтэйчүүд судлалын салбар зөвлөлийн дарга бөгөөд ерөнхий мэргэжилтэнд хүлээлгэж өгнө.

1.2.13. Орон нутагт томилолтоор ажилласан тухай үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналыг

томилолт дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газарт ирүүлнэ.

1.2.14. Хариуцсан аймаг, дүүргийн эх барих, эмэгтэйчүүдийн тусламжийг сайжруулах чиглэлээр хийсэн ажлын тайланг хагас, бүтэн жилээр бичиж, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газарт ирүүлнэ.

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 03 сарын 09-ны өдрийн  
А/ дугаар тушаалын 2 дугаар  
хавсралт



**ХҮҮХЭД СУДЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД, ЗӨВЛӨХ ЭМЧ, МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ОРОН НУТГИЙГ ХАРИУЦАН АЖИЛЛАХ ХУВААРЬ, АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ**

**2.1 АЖИЛЛАХ ХУВААРЬ**

№	Нэрс	Албан тушаал	Зэрэг, цол	Аймгийн нэр
5.	Д.Агиймаа	АШУҮИС-ийн ХАТ-ийн эрхлэгч	АУ-ны доктор, тэргүүлэх зэргийн эмч	Увс, Дархан-Уул
6.	Ц.Алтантуяа	ЭХЭМҮТ, ХЭ-ийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал	АШУ-ны магистр тэргүүлэх зэргийн эмч	Хөвсгөл, Говь-Алтай
7.	Б.Баясгалантай	АШУҮИС-ийн ХАТ-ийн багш	АУ-ны доктор, тэргүүлэх зэргийн эмч	Баянхонгор, Баян-Өлгий
8.	Т.Болормаа	ЭХЭМҮТ, ЗСХЭЭС-ийн зтасгийн эрхлэгч	АУ-ны доктор, тэргүүлэх зэргийн эмч	Хэнтий, Сүхбаатар
9.	Д.Гэрэлмаа	Интермед эмнэлгийн хүүхдийн эмч	АУ-ны магистр тэргүүлэх зэргийн эмч	Ховд, Сэлэнгэ
10.	Д.Даваасүрэн	"Энх-Ирээдүй" хүүхдийн эмнэлгийн ерөнхий эмч	АУ-ны доктор, тэргүүлэх зэргийн эмч	Өвөрхангай, Завхан
7.	Д.Малчинхүү	АШУҮИС-ийн ХАТ-ийн профессор	МУ-ын ардын эмч, АУ-ны доктор, профессор	Булган
8.	П.Отгонбаяр	"Бүүвэй ээж" эмнэлгийн мэдрэлийн зөвлөх эмч	АУ-ны доктор, тэргүүлэх зэргийн эмч	Дундговь, Өмнөговь
9.	А.Оюунчимэг	ЭХЭМҮТ, ЭТҮЧА-ны дарга	АУ-ны магистр тэргүүлэх зэргийн эмч	Өвөрхангай, Говьсүмбэр
10.	Н.Ууганцэцэг	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эхийн холбооны менежер	АУ-ны магистр, тэргүүлэх зэргийн эмч	Дорноговь Орхон
11.	Г.Эрдэнэтуяа	АШУҮИС-ийн ХАТ-ийн дэд профессор	АУ-ны доктор, тэргүүлэх зэргийн эмч	Төв Архангай

## 2.2 АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ

2.2.1. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, төлөвлөгөөний төсөлд санал өгч, дэмжлэг үзүүлэх;

2.2.2. Хүүхэд, нярайн тусламж үйлчилгээний чиглэлээр мөрдөгдөж буй стандарт, журам, заавар, тушаалын хэрэгжилтэд хяналт тавих;

2.2.3. Амаржих газрууд, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн хүүхэд, нярайн тусламж, үйлчилгээний байдалтай танилцах, зөвлөгөө өгөх;

2.2.4. Мэргэжлийн чиглэлээр ажлын байрны сургалт зохион байгуулах;

2.2.5. Хүүхэд, нярайн тусламжийн зохион байгуулалтын болон мэргэжлийн тусламжийг үзүүлэх;

2.2.6. Тухайн орон нутгийн хүүхдийн эндэгдлийн байдалд дүгнэлт өгч, шаардлагатай тохиолдолд орон нутагт ажиллаж, эмнэлзүй, эмгэг судлалын хуралд оролцож, зөвлөмж өгөх;

2.2.7. ХӨЦМ, Эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж болон нярайн нэн шаардлагатай тусламжийн байнгын бэлэн байдал, эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн хангамж, хүний нөөцийн хүрэлцээ, чадавхийг үнэлж, орон нутгийн шийдвэр гаргагчдад танилцуулж, асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.2.8. Хүүхэд, өсвөр үеийн тусламжийн байдалтай танилцах, зөвлөгөө өгөх;

2.2.9. Орон нутгийн хүүхдийн ерөнхий мэргэжилтэн, хүүхдийн эмч нартай байнгын уялдаа холбоотой ажиллаж зөвлөгөө өгөх;

2.2.10. Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн эмч нарт цахимаар зөвлөгөө өгөх;

2.2.11. Орон нутагт ажилласан тохиолдолд тайлан бичиж Эрүүл мэндийн газрын удирдлага, хүүхдийн анагаахын салбар зөвлөлийн дарга бөгөөд ерөнхий мэргэжилтэнд хүлээлгэж өгнө;

2.2.12. Орон нутагт томилолтоор ажилласан тухай үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналыг томилолт дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газарт ирүүлнэ;

2.2.13. Хариуцсан аймаг, дүүргийн хүүхэд, өсвөр үеийн тусламжийг сайжруулах чиглэлээр хийсэн ажлын тайланг хагас, бүтэн жилээр бичиж, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газарт ирүүлнэ.